

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

201.....

Улаанбаатар хот

**ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ
(Шинэчилсэн найруулга)**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь төрийн аудитын үйл ажиллагаа, төрийн аудитыг хэрэгжүүлэх байгууллагын тогтолцоо, хараат бус байдал, бүрэн эрх, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, төрийн аудитыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Төрийн аудитын тухай хууль тогтоомж

2.1.Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль, Төсвийн тухай хууль, хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Төрийн аудитын үндсэн зарчим

3.1.Төрийн аудит нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

3.1.1.хууль дээдлэх;

3.1.2. хараат бус, бие даасан байх;

3.1.3. ил тод, бодитой байх;

3.1.4. нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх;

3.1.5.төрийн аудитын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, стандартад нийцсэн байх.

4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

4.1.Энэ хуулийг төрийн аудитын байгууллагаас Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, төрийн болон төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төсвөөс санхүүжилт авсан хуулийн этгээд, төсвөөс санхүүгийн дэмжлэг авсан төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, Засгийн газрын тусгай зориулалтын сангийн санхүүгийн тайлан, төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгө болон Монгол Улсын Засгийн газар, төсвийн байгууллагад олгосон зээл, тусламж, хандив, өрийн хэрэгслийн төлөвлөлт, ашиглалт, зарцуулалт, үр дүн, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, үйл ажиллагааны гүйцэтгэлд

аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, акт, албан шаардлага өгөх, түүний биелэлтийг хянахад дагаж мөрдөнө.

5 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо

5.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

5.1.1.“албан шаардлага” гэж аудитаар илэрсэн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, арилгуулах талаар өгөх захиргааны актыг;

5.1.2.“аудитын баг” гэж аудитын батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр томилогдсон аудитор, хянан удирдах ажилтан, нарийн мэргэжлийн мэргэжилтэн, шинжээчийг;

5.1.3.“аудитын чанарын удирдлагын тогтолцоо” гэж хэрэглэгч олон нийтийн хэрэгцээ шаардлагад нийцсэн аудитын тайлан бэлтгэх зорилгоор аудитыг төлөвлөхөөс эхлэн аудитын тайлан, дүгнэлт гарах хүртэлх үе шатны удирдлагын хяналтын горим, чанарын баталгаажуулалтын хяналтыг;

5.1.4.“аудитын зардал” гэж аудитын үйл ажиллагаанд зарцуулах аудитын багийн цалин хөлс, томилолт, тусгай шинжээчийн болон лабораторийн шинжилгээний зардал, хянан удирдах үйл ажиллагааны болон шууд бус бусад зардлыг;

5.1.5.“аудитын нотлох зүйлс” гэж аудитор аудитын санал дүгнэлтийн үндэслэл болгоход ашигласан бүх төрлийн баримт, мэдээллийг;

5.1.6.“гүйцэтгэлийн аудит” гэж шалгагдагч байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ өөрийн нөөцийг хэрхэн арвич хямгач, үр ашигтай бөгөөд үр нөлөөтэй ашиглаж байгаад аудит хийж, дүгнэлт, зөвлөмж өгөх үйл ажиллагааг;

5.1.7.“нийцлийн аудит” гэж шалгагдагч байгууллага үйл ажиллагаандаа хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актаар тогтоосон шаардлагыг сахин биелүүлж байгаа эсэхэд аудит хийж дүгнэлт гаргаж баталгаажуулах үйл ажиллагааг;

5.1.8.“санхүүгийн тайлангийн аудит” гэж шалгагдагч байгууллагын санхүүгийн тайланд санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон холбогдох стандартад нийцүүлэн үнэн зөв тайлагнасан эсэх талаар санал дүгнэлт гаргаж баталгаажуулах үйл ажиллагааг;

5.1.9.“төрийн аудит” гэж энэ хуулийн 4.1-т заасан үйлчлэлийн хүрээнд гүйцэтгэх аудитын үйл ажиллагааг;

5.1.10.“төрийн аудитор” гэж төрийн аудитын үйл ажиллагааг гардан гүйцэтгэж, хяналт тавьж байгаа төрийн аудитын байгууллагын албан хаагчийг;

5.1.11.“төрийн аудит хийх тусгай зөвшөөрөл” (цаашид “тусгай зөвшөөрөл” гэх) гэж төрийн аудит хийх үйл ажиллагааг тогтоосон хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу эрхлэн явуулах эрхийг хуулийн этгээдэд Монгол Улсын Ерөнхий аудиторгоос олгосон албан ёсны баримт бичгийг;

5.1.12.“төрийн аудитын тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэж төрийн аудит хийх үйл ажиллагаа эрхлэхээр Монгол Улсын Ерөнхий аудиторгоос олгосон тусгай зөвшөөрөлтэй этгээдийг;

5.1.13.“төлбөрийн акт” гэж аудитаар төсвийн болон төсвийн бус өмч хөрөнгийн хууль бус зарцуулалтад төрийн аудитын байгууллагаас тавигдах захиргааны актыг;

5.1.14.“шалгагдагч байгууллага” гэж Монгол Улсын Нэгдсэн төсвийн орлого бүрдүүлдэг, түүнээс санхүүжилт, санхүүгийн дэмжлэг авдаг, олон улсын байгууллага, гадаад орны Засгийн газраас хандив, тусламж авсан төрийн байгууллага болон бусад байгууллага,

иргэн, төсөл хөтөлбөр, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг.

6 дугаар зүйл.Төрийн аудитын төрөл, хэлбэр

6.1.Төрийн аудит дараахь төрлөөс бүрдэнэ:

6.1.1.санхүүгийн тайлангийн;

6.1.2.гүйцэтгэлийн;

6.1.3.нийцлийн.

6.2.Аудит хийх явцад гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай эрсдэл бүхий асуудал илэрсэн бол Монгол Улсын Ерөнхий аудиторын шийдвэрээр эрсдэлийн аудит хийж болно.

6.3.Өмнө нь хийсэн аудитын акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах давтан аудит хийж болно.

6.4.Төрийн аудитын байгууллага нь нэгдсэн, хамтарсан, зэрэгцээ болон бусад хэлбэрээр аудитын үйл ажиллагааг явуулж болно.

7 дугаар зүйл.Төрийн аудитын байгууллагын хараат бус байдал

7.1.Төрийн аудитын байгууллага нь зохион байгуулалт, үйл ажиллагаа, төсвийн хувьд бие даасан, хараат бус байх бөгөөд Монгол Улсын Их хуралд ажлаа хариуцан тайлагнана.

7.2.Төрийн аудитын байгууллагын аудитын болон бусад үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, хяналт тавих, хуульд зааснаас бусад тохиолдолд үйл ажиллагаатай нь холбогдуулан тайлан, мэдээлэл шаардахыг хориглоно.

7.3.Төрийн аудитын байгууллагыг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь хөндлөнгөөс нөлөөлөх, дарамт шахалт үзүүлэхийг хориглоно.

7.4.Төрийн аудитын байгууллагын албан хаагч ажил үүргээ гүйцэтгэх явцад саад учруулах, нөлөөлөх, хөндлөнгөөс оролцох, хяналт тавих, ажлаа тайлагнахыг шаардах зэргээр хараат бус байдалд нь нөлөөлөхийг хориглоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ.ТӨРИЙН АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

8 дугаар зүйл. Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх

8.1.Төрийн аудитын байгууллага шалгадагч байгууллагын үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөө, арвилан хэмнэлт, төсвийн орлого бүрдүүлэлт, зарцуулалт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагнал, дотоод хяналт, хууль тогтоомжийн хэрэгжилтэд аудит хийнэ.

8.2.Олон улсын байгууллага, гадаад орны санхүүжилтээр ажилладаг байгууллага, аж ахуйн нэгж, төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаанд тэдний хүсэлтээр аудит хийж болно.

8.3.Засгийн газрын тусгай зориулалтын сан, төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгө болон олон улсын байгууллага, гадаад орны Засгийн газар, байгууллага, иргэдээс Монгол Улсын Засгийн газар, төсвийн байгууллагад олгосон зээл, тусламж, хандив, өрийн хэрэгслийн төлөвлөлт, ашиглалт, зарцуулалт, үр дүнд аудит хийнэ.

8.4. Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнд аудит хийнэ.

8.5. Төрийн аудитын байгууллага шалгагдагч байгууллагын банкин дахь дансны мэдээллийг банкны байгууллагаас гаргуулан авна. Төрийн аудитын байгууллагаас шаардсан мэдээллийг арилжааны болон бусад банк саадгүй гаргаж өгнө.

8.6. Эрх бүхий байгууллагын гүйцэтгэх ажилд зориулсан улсын төсвийн хөрөнгийн зарцуулалтад аудит хийх, түүнд чанарын хяналтыг хэрэгжүүлэх ажлыг Монгол Улсын Ерөнхий аудиторын санал болгож Улсын Их Хурлын даргын итгэмжлэлээр эрх олгосон аудитор гүйцэтгэнэ.

8.7. Шаардлагатай тохиолдолд тодорхой асуудлаар аудит хийж, дүгнэлт гаргана.

8.8. Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын жилийн төсвийн төсөлд, уг төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын Байнгын хороо, нам, эвслийн бүлгээс гаргасан саналын талаар дүгнэлт гаргаж, Улсын Их Хуралд хүргүүлнэ.

8.9. Орон нутгийн төсвийн төсөлд аудит хийж санал, дүгнэлт гарган аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

8.9. Төрийн аудитын байгууллага бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шаардлагатай тохиолдолд тусгай мэдлэг бүхий мэргэжилтнийг аудитад шинжээчээр татан оролцуулна.

8.10. Аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах акт тогтоох, зөрчлийг арилгуулах албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

8.11. Албан тушаалтан хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитын явцад илэрвэл түүнд хууль тогтоомжид заасны дагуу сахилгын хариуцлага тооцуулах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ. Эрх бүхий байгууллага, албан тушаалтан уг асуудлыг зохих журмын дагуу хэрхэн шийдвэрлэсэн тухайгаа төрийн аудитын байгууллагад тогтоосон хугацаанд мэдэгдэнэ.

8.12. Төрийн аудитын байгууллагаас төсвийн байгууллага, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчит буюу тэдгээр өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн ашиглалт, зарцуулалтад аудит хийх явцад гэмт хэргийн шинжтэй нөхцөл байдал илэрвэл энэ тухай эрх бүхий байгууллагад мэдэгдэж холбогдох баримт бичгийг шилжүүлэн шалгуулна. Эрх бүхий байгууллага шилжүүлсэн хэргийн талаар гаргасан шийдвэрээ холбогдох хуульд заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад мэдэгдэнэ.

8.13. Хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

9 дүгээр зүйл. Санхүүгийн тайлангийн аудит

9.1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг, улс, орон

нутгийн бүх шатны төсвийн захирагч төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг, Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээд санхүүгийн тайланг холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагад нийцүүлэн бэлтгэж, тогтоосон хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

9.2.Төрийн аудитын байгууллага нь Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гарган шалгадагч байгууллагад хүргүүлэх ба төсвийн ерөнхийлөн захирагч түүний эрхлэх асуудлын хүрээний байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг эрх бүхий байгууллагад танилцуулж, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын тайлан, дүгнэлтийн хувийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

9.3.Санхүүгийн тайланд аудит хийх үйл ажиллагааг зохицуулсан журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор баталж, мөрдүүлнэ.

9.4.Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд аудит хийхдээ энэ хуульд заасан журмын дагуу авсан тусгай зөвшөөрөлтэй аудитын хуулийн этгээдээр гэрээлэн гүйцэтгүүлж болно.

9.5.Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитыг гэрээгээр гүйцэтгэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, хяналт тавих, аудитын тайланг баталгаажуулах журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор баталж мөрдүүлнэ.

9.6.Санхүүгийн тайлангийн аудитыг гэрээлэн гүйцэтгэх аудитын үйлчилгээний төлбөрийн хэмжээ, жишгийг Төрийн аудитын байгууллагын саналыг үндэслэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтоож, шалгадагч байгууллага түүнийг жилийн төсөвтөө тусгана.

10 дугаар зүйл. Гүйцэтгэлийн аудит

10.1.Төрийн аудитын байгууллага гүйцэтгэлийн аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторов болон түүний эрх олгосноор Аймаг, нийслэл дэх төрийн аудитын газрын даргын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлнэ.

10.2.Гүйцэтгэлийн аудитад тусгай мэргэжил эзэмшсэн хүн, мэргэжилтнийг гэрээний үндсэн дээр шинжээчээр татан оролцуулж, үйлчилгээ, зөвлөгөө авч болно.

10.3.Гүйцэтгэлийн аудит хийх үйл ажиллагааг зохицуулсан журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор баталж, мөрдүүлнэ.

11 дүгээр зүйл. Нийцлийн аудит

11.1.Төрийн аудитын байгууллага нийцлийн аудитыг дангаар болон санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн аудиттай хослуулан хэрэгжүүлнэ.

11.2.Нийцлийн аудитад эрх зүйн мэргэжилтнийг гэрээний үндсэн дээр шинжээчээр татан оролцуулж, үйлчилгээ, зөвлөгөө авч болно.

11.3.Нийцлийн аудит хийх үйл ажиллагааг зохицуулсан журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор баталж, мөрдүүлнэ.

12 дугаар зүйл. Аудитыг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах

12.1.Төрийн аудитын байгууллага нь аудит хийх төрөл, хэлбэрийг санхүүгийн удирдлага, арга зүйг менежемент, шинжлэх ухаан, техник, технологийн дэвшилттэй уялдуулан байнга боловсронгуй болгож, үйл ажиллагаандаа нэвтрүүлж байна.

12.2.Төрийн аудитын байгууллага нь аудитыг гүйцэтгэхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын болон холбогдох стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, аргачлалыг баримтална.

12.3.Төрийн аудитын байгууллага аудитыг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад гарах нэмэлт зардлыг нөхөх үүднээс шалгагдагч байгууллагаас төлбөр авч болно.

12.4.Төрийн аудитын байгууллагаас хийх аудитыг аудитын баг тус хуулийн 12.1-д заасан стандарт, журам, аргачлалын дагуу төлөвлөж, хэрэгжүүлж, тайлагнана.

12.5.Монгол Улсын Ерөнхий аудитор аудитын багийн ажилд тавих чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлж хэрэгжилтийг хангуулна.

12.6.Аудитыг гүйцэтгэж тайлангийн төсөл бэлтгэсний дараа төрийн аудитын байгууллага дараахь арга хэмжээ авна:

12.6.1.Шалгагдагч байгууллагад тайлангийн төслийг хүргүүлж ажлын 10 хүртэлх хоногийн дотор саналаа ирүүлэхийг даалгах;

12.6.2.Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн саналыг судлан үндэслэлтэй гэж үзвэл тайланд тусгах;

12.6.3.Энэ зүйлийн 12.6.1 дэх хэсэгт заасан хугацаанд санал ирүүлээгүй бол саналгүйд тооцох;

12.6.4.Төрийн аудитын байгууллага аудитын тайланг шалгагдагч байгууллага, шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурал, бусад байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

13 дугаар зүйл. Баримт, мэдээлэл гаргуулах

13.1.Төрийн аудитын байгууллага, төрийн аудитор нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах баримт, мэдээллийг үнэ төлбөргүй гаргуулан авна.

13.2.Энэ хуульд заасан шалгагдагч байгууллага, албан тушаалтан нь төрийн аудитын байгууллага, төрийн аудитороос шаардсан баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд саадгүй гаргаж өгөх үүрэгтэй.

13.3.Шалгагдагч байгууллага, албан тушаалтан нь гадаад хэл дээр бэлтгэгдсэн баримт, мэдээллийг төрийн албан ёсны хэл дээр хөрвүүлж Төрийн аудитын байгууллагад үнэ төлбөргүй гаргаж өгнө.

14 дүгээр зүйл. Мэдээллийн нууцлалыг хадгалах

14.1.Төрийн аудитор аудит хийх явцад олж мэдсэн төрийн болон албаны нууц, хувь хүний нууцад хамаарах мэдээллийг уг мэдээллийг өгсөн байгууллагынхтай ижил түвшинд нууцалж хамгаалах үүрэгтэй.

14.2.Шалгагдагч байгууллага, албан тушаалтан нь нууц гэдгээр халхавчлан Төрийн аудитын байгууллага, төрийн аудиторт баримт, мэдээллийг гаргаж өгөхөөс үндэслэлгүй татгалзахыг хориглоно.

15 дугаар зүйл. Төрийн аудитын байгууллагын баримт бичиг, шийдвэр.

15.1.Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэх аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг Монгол Улсын Ерөнхий аудитор, түүний эрх олгосноор Аймаг, нийслэл дэх төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор батална.

15.2.Төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор, түүний эрх олгосноор Аймаг, нийслэл дэх төрийн аудитын газрын тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулна.

15.3.Энэ хуулийн 8.10-т заасан бүрэн эрхийн хүрээнд Төрийн аудитын байгууллагаас акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор баталж, мөрдүүлнэ.

15.4.Албан тушаалтан хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрвэл түүнд хууль тогтоомжид заасан хариуцлага тооцуулах саналыг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

15.5.Төрийн аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, аудит хийлгэхээс зайлсхийсэн, шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөхөөс үндэслэлгүй татгалзсан, аудитад нөлөөлөхийг оролдсон албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.

15.6. Монгол Улсын Ерөнхий аудитор Үндэсний аудитын газрын чиг үүрэгтэй холбоотой аливаа асуудлаар мэдээлэл, илтгэл, тайлан бэлтгэж холбогдох байгууллага, албан тушаалтанд өгч болно.

15.7. Монгол Улсын Ерөнхий аудитор нийтийн ашиг сонирхолд хамаарах аливаа асуудлаар санал, зөвлөмж бэлтгэж Улсын Их Хурал, түүний Байнгын хороо, холбогдох бусад байгууллага, албан тушаалтанд танилцуулж болно.

16 дугаар зүйл. Шалгагдагч байгууллагын эрх, үүрэг

16.1.Шалгагдагч байгууллага төрийн аудитын байгууллагын аудитын тайлангийн төсөлд тогтоосон хугацаанд санал өгч болно.

16.2.Төрийн аудитын байгууллагаас тогтоосон акт, өгсөн албан шаардлагыг үндэслэлгүй гэж үзэн хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд саналаа холбогдох нотлох баримтын хамт Монгол Улсын Ерөнхий аудитор, түүний эрх олгосон этгээдэд ирүүлж, шийдвэрлүүлнэ.

16.3.холбогдох байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 16.1, 16.2-д заасан санал, албан шаардлагыг хэрхэн шийдвэрлэсэн тухайгаа Төрийн аудитын байгууллагад ажлын 10 хоногийн дотор мэдэгдэнэ.

16.4.Шалгагдагч байгууллага нь төрийн аудиторын шаардсан баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд, саадгүй, үнэ төлбөргүй гаргаж өгөх үүрэгтэй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ.ГОМДОЛ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ

17 дугаар зүйл. Гомдол гаргах, шийдвэрлэх

17.1.Албан тушаалтан, хуулийн этгээд төрийн аудитын байгууллага, аудиторын гаргасан аудитын дүгнэлт, шийдвэрийг эс зөвшөөрвөл Монгол Улсын Ерөнхий аудиторт гомдол гаргаж болно.

17.2.Үндэсний аудитын газрын дэргэд аудитын үйл ажиллагаатай холбогдуулж гаргасан гомдлыг хянан хэлэлцэх комисс ажиллуулна. Комиссын гишүүд нь орон тооны бус байх бөгөөд бүрэлдэхүүний 40-с доошгүй хувьд иргэд, төрийн болон бус байгууллагаас сонгогдсон гишүүд байна.

17.3.Гомдол хянан хэлэлцэх Комиссын ажиллах журмыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо батална

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО, УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

18 дугаар зүйл. Төрийн аудитын байгууллагын тогтолцоо

18.1.Төрийн аудитын байгууллага нь Үндэсний аудитын газар, түүний харьяа Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газраас бүрдэнэ.

18.2.Монгол Улсын Ерөнхий аудитор Үндэсний Аудитын Газрыг тэргүүлнэ. Ерөнхий Аудиторын орлогч нь аудитын болон орон нутаг дахь төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг Монгол Улсын Ерөнхий аудиторын өмнө хариуцан, зохион байгуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

18.3.Үндэсний аудитын газрын Тамгын газрын дарга нь Үндэсний Аудитын газрын захиргааны удирдлагыг Монгол Улсын Ерөнхий Аудиторын өмнө хариуцан хэрэгжүүлнэ.

18.4.Төрийн аудитын байгууллагын орон тооны дээд хязгаарыг Монгол Улсын Ерөнхий аудиторын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо батална.

18.5.Энэ хуулийн 18.4.-т заасан орон тооны дээд хязгаарыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудитор Үндэсний аудитын газрын болон Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог батална.

19 дүгээр зүйл. Монгол Улсын Ерөнхий аудитор, түүний орлогч

19.1.Төрийн аудитын байгууллагыг Монгол Улсын Ерөнхий аудитор тэргүүлнэ. Монгол Улсын Ерөнхий аудитторыг Улсын Их Хурлын даргын санал болгосноор Улсын Их Хурал 9 жилийн хугацаагаар нэг удаа томилно. Хэрэв Улсын Их Хурал санал болгосон хүнийг дэмжихгүй бол нэг удаа өөр хүний нэрийг дэвшүүлнэ.

19.2.Монгол Улсын Ерөнхий аудитор оор эдийн засаг, хууль, төрийн захиргаа болон холбогдох бусад чиглэлээр дээд боловсролын зэрэгтэй, төрийн албаны удирдах албан тушаалд 10-аас дээш жил ажилласан, 45-аас дээш настай, төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй, гэмт хэрэг үйлдэж, гэм буруутайд тооцогдож байгаагүй, аливаа ашиг сонирхлын зөрчилгүй Монгол Улсын иргэнийг томилно.

19.3.Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогчийг Монгол Улсын Ерөнхий аудиторов санал болгосноор Улсын Их Хурал томилж чөлөөлнө. Хэрэв Улсын Их Хурал санал болгосон хүнийг дэмжихгүй бол нэг удаа өөр хүний нэрийг дэвшүүлнэ.

19.4.Монгол Улсын Ерөнхий аудиторов эзгүйд түүний шийдвэрээр Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч бүрэн эрхийг нь хэрэгжүүлнэ.

19.5.Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч Монгол Улсын Ерөнхий аудиторов өмнө ажлаа хариуцна.

19.6.Монгол Улсын Ерөнхий аудитор, түүний орлогчийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан бол холбогдох албан тушаалтан энэ тухай Улсын Их Хурлын даргад хорин дөрвөн цагийн дотор мэдэгдэнэ. Үүнээс бусад тохиолдолд түүнийг албадан саатуулах, цагдан хорих болон шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, гэр, албан өрөө, биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно.

19.7.Монгол Улсын Ерөнхий аудитор, түүний орлогчийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татан шалгахтай холбогдуулан бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг эрх бүхий байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

19.8.Монгол Улсын Ерөнхий аудитор, түүний орлогчийн бүрэн эрх дараахь тохиолдолд Улсын Их Хурлын шийдвэр гарснаар хугацаанаас өмнө дуусгавар болно:

19.8.1.өөр ажил, албан тушаалд томилогдсон, хуулиар тогтоосон болзол, журам, шалгуурын дагуу сонгогддог албан тушаалд нэр дэвшсэн;

19.8.2.гэмт хэрэг үйлдсэн болохыг тогтоосон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;

19.8.3. эрүүл мэндийн байдлын улмаас бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон.

19.8.4.өөрөө хүсэлт гаргасан бол

20 дугаар зүйл. Монгол Улсын Ерөнхий аудиторын бүрэн эрх

20.1. Монгол Улсын Ерөнхий аудитор нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 20.1.1.төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулж удирдах;
- 20.1.2.төрийн аудитын байгууллагыг гадаад, дотоод харилцаанд төлөөлөх;
- 20.1.3.Улсын Их Хурлын чуулганы болон Засгийн газрын хуралдаанд зөвлөх эрхтэй оролцох;
- 20.1.4.төрийн аудитын байгууллагын урт болон дунд хугацааны стратеги төлөвлөгөө, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;
- 20.1.5.аудитын үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журам, заавар батлах;
- 20.1.6. төрийн аудитын тусгай зөвшөөрөл олгох;
- 20.1.7.төрийн болон албаны нууцад хамаарах аудитын үйл ажиллагааны журмыг тагнуулын төв байгууллагын даргатай хамтран батлах;
- 20.1.8.аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, тайланг хянаж батлах;
- 20.1.9.энэ хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд аудит, нягтлан бодох бүртгэл, захиргаа, хүний нөөц, санхүүгийн үйл ажиллагааг чиглүүлж, шийдвэр гаргах;
- 20.1.10.Улсын Их Хурлаас баталсан төсвийг хуваарилах, Төрийн аудитын байгууллагын төсвийн зарцуулалтад хяналт тавих;
- 20.1.11.төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, хуваарийг батлах;
- 20.1.12.Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийг томилуулах, чөлөөлүүлэх тухай саналаа Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх;
- 20.1.13.төрийн аудитын байгууллагын ажилтан, албан хаагчийг томилох, чөлөөлөх, урамшуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, сахилгын шийтгэл оногдуулах;
- 20.1.14.төрийн аудитын байгууллагын албан хаагчийн мэргэшсэн байдал, ур чадвар, дадлага туршлагыг харгалзан албан тушаалд тавигдах шаардлага, сонгон шалгаруулах, дэвшүүлэх, эсхүл бууруулан томилох, сэлгүүлэн ажиллуулах журмыг батлах;
- 20.1.15.эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргах;
- 20.1.16.хуульд заасан бусад.

20.2.Монгол Улсын Ерөнхий аудитор бүрэн эрхийнхээ зарим хэсгийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч, газрын дарга, нэгжийн удирдлагад шилжүүлж болох бөгөөд энэ нь түүнийг энэ хуулиар хүлээсэн үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

21 дугаар зүйл. Төрийн аудитын байгууллага

21.1.Үндэсний аудитын газар нь Монгол Улсын төрийн аудитын дээд байгууллага байна.

21.2.Төрийн аудитын байгууллага нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах Улсын Их Хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, дүгнэлт гаргах эрх бүхий хараат бус, хөндлөнгийн, хяналтын дээд байгууллага байна.

21.3.Төрийн аудитын байгууллага болон Монгол Улсын Ерөнхий аудиторын үйл ажиллагаанд Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улсын Их Хурлаас бусад байгууллага, албан тушаалтан хяналт тавих, үүрэг даалгавар өгөхийг хориглоно.

22 дугаар зүйл. Үндэсний аудитын газар

22.1. Үндэсний аудитын газар нь Монгол Улсын Ерөнхий аудиторт хуульд заасан чиг үүрэг, эрхлэх асуудлынхаа хүрээнд стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг нь зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлгээ өгөхөд нь мэргэжил, арга зүй, эрх зүй, техник, зохион байгуулалтын үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

22.2. Үндэсний аудитын газар нь Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, Монгол Улсын Ерөнхий аудиторов хуульд нийцсэн шийдвэрт захирагдана.

22.3. Үндэсний аудитын газар Улаанбаатар хотод байрлах ба тогтоосон журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

23 дугаар зүйл. Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар

23.1.Төрийн аудитын үйл ажиллагааг орон нутгийн хэмжээнд тухайн Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ.

23.2.Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

23.3.Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга нь Ерөнхий аудиторос шилжүүлсэн эрх хэмжээний хүрээнд тушаал гаргана.

23.4.Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга нь тухайн байгууллагын төсвийг захиран зарцуулах ба үйл ажиллагаагаа тогтоосон хугацаанд Монгол Улсын Ерөнхий аудиторов өмнө хариуцан тайлагнана.

24 дүгээр зүйл.Төрийн аудитын байгууллагын аудитын хэтийн болон жилийн төлөвлөлт

24.1.Үндэсний аудитын газар төрийн аудитын байгууллагын аудитын хэтийн болон жилийн төлөвлөгөөг боловсруулна.

24.2.Төрийн аудитын байгууллагын аудитын хэтийн болон жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа өөрийн боломжит нөөц, нийтийн ашиг сонирхлыг харгалзана.

24.3.Төрийн аудитын байгууллагын хэтийн болон жилийн аудитын сэдвийг төлөвлөхдөө дараахь зүйлийг харгалзан үзнэ. Үүнд:

24.3.1.хууль тогтоомжоор тусгайлан ногдуулсан аудит хийх чиг үүрэг;

24.3.2.Улсын Их Хурал, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн санал;

24.3.3.орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал;

24.3.4.олон улсын аудитын бусад байгууллагаас хийхээр төлөвлөсөн аудит;

24.3.5.иргэд, олон нийтийн анхааралд байгаа үнэн зөв хариу хүссэн асуудал;

24.3.6.олон улсын болон бүс нутгийн нийтлэг тулгамдсан асуудал;

24.3.7.тулгамдсан болон гэнэтийн хэрэгцээ шаардлага;

24.3.8.бусад

25 дугаар зүйл. Төрийн аудитын байгууллагын төсөв санхүүжилт

25.1.Төрийн аудитын байгууллага нь улсын төсөв болон бусад эх үүсвэрээс санхүүжнэ.

25.2.Төрийн аудитын байгууллагын төсвийн төслийг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо хянана.

25.3.Энэ хуулийн 25.2.-т заасан хянагдсан төсвийн төслийг санхүү,төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын нэгдсэн төсөвт нэгтгэнэ.

25.4.Төсөв нь Төрийн аудитын байгууллага үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх нөхцөлийг хангасан байх бөгөөд уг төсөвт Үндэсний аудитын газар, Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны зардлаас гадна лабораторийн шинжилгээ хийлгэх, гэрээт аудитор, мэргэжлийн байгууллага, шинжээч ажиллуулах зардал, ажилтнуудын мэргэшил, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, байгууллагын хөрөнгө оруулалтад шаардагдах хөрөнгийг тусгана.

26 дугаар зүйл.Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайлан

26.1.Төрийн аудитын байгууллага үйл ажиллагаагаа жил бүр Улсын Их Хуралд тайлагнана. Төрийн аудитын байгууллагын жилийн үйл ажиллагааны тайланд тухайн жилийн санхүүгийн тайлан тусгагдсан байна.

27 дугаар зүйл.Төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудит

27.1.Төрийн аудитын байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайланд Улсын Их Хурлын даргын томилсон аудитын хуулийн этгээд аудит хийж, тайлан, дүгнэлтийг Улсын Их Хуралд хүргүүлнэ.

27.2.Энэ хуулийн 27.1-т заасан этгээд аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан стандарт, журмын дагуу хийж гүйцэтгэнэ. Аудит хийх хугацаанд мэдээлэл цуглуулахдаа Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн нэгэн адил бүрэн эрхийг эдлэх бөгөөдТөрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлж болохгүй.

ТАВДУГААР БҮЛЭГ.ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧ ТҮҮНИЙ ЭРХ ҮҮРЭГ

28 дугаар зүйл.Төрийн аудитын байгууллагын албан тушаалын бүрэлдэхүүн

28.1.Монгол Улсын Ерөнхий аудитор төрийн аудитын байгууллагын хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ төрийн албаны нийтлэг хууль тогтоомжийн хүрээнд өөрийн онцлогт тохирсон тогтолцоог боловсруулж мөрдөнө.

28.2.Төрийн аудитын байгууллагын хүний нөөц нь Монгол Улсын Ерөнхий аудитор, түүний орлогч, газрын дарга/захирал-тэргүүлэх аудитор, аудитын менежер, ахлах аудитор, аудитор болон бусад албан хаагчдаас бүрдэнэ.

28.3.Монгол Улсын Ерөнхий аудитор, түүний орлогч, газрын дарга/захирал-тэргүүлэх аудитор, аудитын менежер, ахлах аудитор, аудитор нь төрийн тусгай албан хаагч байна.

28.4.Төрийн аудитын байгууллага нь үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах үүрэг бүхий захиргааны алба, ажилтантай байна.

28.5.Төрийн аудитын байгууллагад чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий туслах ажилтан ажиллана.

29 дүгээр зүйл.Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн тангараг

29.1.Төрийн аудитын байгууллагын албан хаагч нь “Төрийн аудитын байгууллагын албан хаагч би хөндлөнгийн аливаа нөлөөнд үл автан, гагцхүү хуульд захирагдан үйл ажиллагаагаа явуулж, аудиторын ёс суртахууны хэм хэмжээг чанд сахиж, албан үүргээ үнэнч шударгаар биелүүлэхээ тангараглая. Тангарагаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ.” хэмээн тангараг өргөнө.

29.2.Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн тангараг өргөх ёслолыг Төрийн албаны тухай хуульд заасан журмын дагуу зохион байгуулна.

30 дугаар зүйл.Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн ёс зүй

30.1.Монгол Улсын Ерөнхий аудитор төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд шударга ёсыг сахиулах үүднээс ёс зүйн дүрэм баталж мөрдүүлнэ.

30.2.Ёс зүйн дүрмийг төрийн аудитын байгууллагын албан хаагчид болон Төрийн аудитын байгууллагын нэрийн өмнөөс төрийн аудитын үйл ажиллагаанд оролцож буй этгээд нэгэн адил дагаж мөрдөнө.

31 дүгээр зүйл.Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн ангилал, зэрэг дэв

31.1.Төрийн аудитын байгууллагын албан тушаалыг дор дурдсанаар ангилна:

- 31.1.1. төрийн аудитын тэргүүн түшээ;
- 31.1.2. төрийн аудитын итгэмжит түшээ;
- 31.1.3. төрийн аудитын эрхэлсэн түшээ;
- 31.1.4. төрийн аудитын зөвлөх түшээ;
- 31.1.5. төрийн аудитын ахлах түшээ;
- 31.1.6. төрийн аудитын түшээ.

31.2.Төрийн аудитын тэргүүн түшээ, итгэмжит түшээ, эрхэлсэн түшээ, зөвлөх түшээ, ахлах түшээ, түшээ нь тус бүртээ тэргүүн зэрэг, дэд зэрэг, гутгаар зэрэг, дөтгөөр зэрэг гэсэн зэрэг дэвтэй байна.

31.3.Төрийн аудитын байгууллагын дараах албан тушаалтан нь дор дурдсан албан тушаалын ангилалд хамаарна:

31.3.1.Монгол Улсын Ерөнхий аудиторт төрийн аудитын тэргүүн түшээ;

31.3.2.Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчид төрийн аудитын итгэмжит түшээ;

31.3.3.Төрийн аудитын байгууллагын газрын дарга/захирал-тэргүүлэх аудиторт төрийн аудитын эрхэлсэн түшээ;

31.3.4.төрийн аудитын байгууллагын аудитын менежерт төрийн аудитын зөвлөх түшээ;

31.3.5.төрийн аудитын байгууллагын ахлах аудиторт төрийн аудитын ахлах түшээ;

31.3.6. төрийн аудитын байгууллагын аудиторт төрийн аудитын түшээ.

31.4.Төрийн аудитын байгууллагын албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор батална.

31.5. Монгол Улсын Ерөнхий аудитор, түүний орлогчийн албан тушаалын зэрэг дэвийг Монгол Улсын Их Хурлын дарга олгоно.

32 дугаар зүйл.Төрийн аудитор, түүний бүрэн эрх, үүрэг

32.1.Төрийн аудитын байгууллагын аудитор дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

32.1.1.Төрийн аудитын байгууллагын чиг үүргийн хүрээнд эрх бүхий албан тушаалтны баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудит хийх,

32.1.2.аудитын үйл ажиллагаанд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас, шаардлага хангасан хэлбэрээр, үнэ төлбөргүй гаргуулан авах;

32.1.3.аудитын явцад шалгадагч байгууллага дээр ажиллах нөхцөл баталгаагаар хангуулах, ажлын талбар, байр сууцанд саадгүй нэвтрэх;

32.1.4.энэ хуулийн 33 дугаар зүйлд заасан баталгааг чөлөөтэй эдлэх;

32.1.5.аудитор нь хууль тогтоомжийг чанд сахих, хөндлөнгийн нөлөөнд үл автан албан үүргээ шударгаар гүйцэтгэх;

32.1.6.аудитын явцад олж мэдсэн төр,болон албаны нууц, хувийн нууцыг бусдад задруулахгүй байх;

32.1.7.аудитын явцад гаргасан дүгнэлт, акт, албан шаардлагын үндэслэлийг бүрэн хариуцах;

32.1.8.хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

33 дугаар зүйл. Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн баталгаа

33.1.Төрийн аудитын байгууллагын албан хаагч дараахь баталгаагаар хангагдана.

33.1.1.нийгмийн;

33.1.2.хууль зүйн;

33.1.3.бусад.

33.2.Төрийн аудитын байгууллагын албан хаагч дараахь нийгмийн баталгаагаар хангагдна.

33.2.1.Төрийн албаны тухай хууль тогтоомжид заасан төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаа, нэмэгдэл баталгаа, цалин хөлс, нөхөн төлбөр, тусламж, шагнал урамшил, тэтгэмжээс гадна энэ хуульд заасан баталгаагаар хангагдана. Үүний тулд Монгол Улсын Ерөнхий аудитор Төрийн аудитын байгууллагын албан хаагчдад зориулсан ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

33.2.2.Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн цалин хөлс нь албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, докторын болон мэргэшлийн зэргийн нэмэгдлээс бүрдэнэ.

33.2.3.Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн цалин хөлс, урамшууллын тогтолцоо төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд өөрийн онцлогт тохирсон байх бөгөөд тэдгээрийн албан тушаалын цалингийн хэмжээг Улсын Их Хурал тогтооно.

33.2.4.аудит хийх бүрэн эрхээ хэрэгжүүлж явахдаа хот, суурин газрын доторхи нийтийн тээврийн хэрэгсэл (таксинаас бусад)-ээр зорчсон тохиолдолд хувиас гарсан зардлыг Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журмын дагуу тухайн байгууллага нь нөхөн олгох;

33.2.5.аудит хийх бүрэн эрхээ хэрэгжүүлж яваад хөдөлмөрийн чадвараа түр алдсан бол хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэмж, албан тушаалын цалингийн зөрүүг хөдөлмөрийн чадвараа түр алдсан хугацааны туршид, тахир дутуу болсон бол тахир дутуугийн тэтгэвэр, албан тушаалын цалингийн зөрүүг тахир дутуугийн тэтгэвэр авч байгаа хугацааны туршид тус тус авах;

33.2.6.албан үүргээ гүйцэтгэх явцад албан хаагчийн амь нас хохирсон тохиолдолд түүний ар гэрт нь 60 сарын албан тушаалын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно.

33.2.7.энэ зүйлийн 33.2.5-д заасан тэтгэвэр, тэтгэмж болон албан тушаалын цалингийн зөрүү, буцалтгүй тусламжийг улсын төсвөөс олгож, уг хөрөнгийг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

33.2.8.хууль тогтоомжид заасан бусад.

33.3.Төрийн аудитын байгууллагын албан хаагч дараахь хууль зүйн баталгаагаар хангагдна.

33.3.1.Төрийн аудитын байгууллагын албан хаагчийг Монгол Улсын Ерөнхий аудиторовн зөвшөөрөлгүйгээр албадан саатуулах, цагдан хорих, баривчлах, орон байр, албан тасалгаа, унаа болон биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно.

33.3.2.Төрийн аудитын байгууллагын албан хаагчийг гүйцэтгэсэн аудиттай нь холбогдуулан аливаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрч, шинжээчээр татан оролцуулах эсэх асуудлыг Монгол Улсын Ерөнхий аудитор шийдвэрлэнэ.

33.3.3. Төрийн аудитын байгууллагын албан хаагч бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас учирсан хохирлыг төр хариуцна.

33.4.Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн бусад баталгаа

33.4.1.албаны чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан Төрийн аудитын байгууллагын албан хаагч болон гэр бүлийнх нь гишүүдийн амь нас, эрүүл мэндэд бодит аюул

заналхийлсэн тохиолдолд цагдаагийн байгууллага тэдний аюулгүй байдал, хараат бус байдлыг хангана.

33.4.2.Төрийн аудитын байгууллагын албан хаагч эрх бүхий албан тушаалтны өгсөн тушаал, даалгаврыг ёсчлон биелүүлснээс үүссэн хохирол, сөрөг үр дагаврыг тушаал, даалгавар өгсөн албан тушаалтан хариуцна.

33.4.3.бүрэн эрхийнхээ хүрээнд Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг байгууллага, албан тушаалтан харьяалал харгалзахгүйгээр биелүүлэх үүрэгтэй.

33.4.4.Төрийн аудитын байгууллагын төв байр төрийн хамгаалалтад байна.

34 дүгээр зүйл.Төрийн аудитын байгууллагын албан хаагчид хориглох зүйл

34.1.Төрийн аудитын байгууллагын албан хаагч Төрийн албаны тухай хууль болон энэ хуульд заасан хориглох зүйлээс гадна дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

34.1.1.аудитыг эрх бүхий албан тушаалтнаас баталсан хөтөлбөр, төлөвлөгөөгүйгээр гүйцэтгэх;

34.1.2.хууль дээдлэх, бусдын нөлөөнд үл автах зарчмыг алдагдуулах;

34.1.3.аливаа ашиг сонирхлын болон, ёс зүйн зөрчил гаргах;

34.1.4.удирдлагын тусгайлан өгсөн зөвшөөрөлгүйгээр албан ажлынхаа талаар нийтэд болон бусдад мэдээлэл өгөх, мэдээлэл дамжуулах;

34.1.5.төрийн аудитын байгууллагын албан хаагч албан үүрэг гүйцэтгэж байх үедээ өөрт нь илэрхий болсон нууцыг үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөнөөс хойш ямар нэгэн зорилгоор ашиглах.

34.2. Төрийн аудитын байгууллагын удирдах, гүйцэтгэх алба хаагч албан тушаал эрхлэх хугацаандаа улс төрийн нам, хөдөлгөөний үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр оролцохыг хориглох бөгөөд хэрэв улс төрийн намын гишүүн байсан бол төрийн жинхэнэ албан тушаалд томилогдсон өдрөөс хойш 7 хоногийн дотор намын гишүүнээс түдгэлзэж, энэ тухайгаа байгууллагын удирдлага болон харьяалах намын байгууллагадаа албан ёсоор бичгээр мэдэгдэнэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ.ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГААС БУСАД БАЙГУУЛЛАГА, ИРГЭДТЭЙ ХАРИЛЦАХ

35 дугаар зүйл.Улсын Их Хуралтай харилцах

35.1.Төрийн аудитын байгууллага үйл ажиллагаагаа жил бүр Улсын Их Хуралд тайлагнана. Төрийн аудитын байгууллагын жилийн тайланд тухайн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан тусгагдана.Хуульд аудит хийхээр заасан аудитын тайланг УИХ-д хүргүүлнэ.

35.2.Төрийн аудитын байгууллага нь өөрийн үйл ажиллагааны хараат бус байдал, төсөв, санхүү, зохион байгуулалттай холбоотой асуудлаар Улсын Их Хуралд санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

36 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газартай харилцах

36.1.Засгийн газар түүний харьяа байгууллагуудад төрийн аудитын байгууллагын аудитын тайланд дурдсан асуудлуудын мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг зохих ёсоор шийдвэрлэсэн талаар харилцан мэдээлэл солилцоно.

37 дугаар зүйл. Иргэд, олон нийттэй харилцах

37.1.Төрийн аудитын байгууллага үйл ажиллагаандаа иргэдийн оролцоог хангаж ажиллах чиглэл баримтална.

37.2.Төрийн аудитын байгууллагын дэргэд орон тооны бус Аудитын иргэний танхим ажиллуулж болно.

37.3.Аудитын иргэний танхимын ажиллах журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор батална.

37.4.Төрийн аудитын байгууллага өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар олон нийтэд мэдээлэл хийж болно.

38 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн байгууллагатай харилцах

38.1.Төрийн аудитын байгууллагын хэвлэл мэдээллийн байгууллагатай харилцах харилцааг зохицуулсан журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор батална.

38.2.Төрийн аудитын байгууллага өөрийн хийсэн төрийн болон албаны, хувь хүний нууцад хамаарах мэдээлэл агуулснаас бусад аудитын тайланг улирал тутам гаргаж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон байгууллагын цахим хуудсаар мэдээлнэ.

38.3.Төрийн аудитын байгууллагын жилийн үйл ажиллагааны тайланг олон нийтэд ил тод болгох зорилгоор байгууллагын цахим хуудаст байршуулна.

ДОЛДУГААР БҮЛЭГ. БУСАД ЗҮЙЛ

39 дүгээр зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

39.1.Төрийн аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, аудит хийлгэхээс зайлсхийсэн, шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөхөөс үндэслэлгүй татгалзсан, аудитад нөлөөлөхийг оролдсон, санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай,сөрөг санал, дүгнэлт авсан, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаар материаллаг шинжтэй зөрчил гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.

39.2.Дараах тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ:

39.2.1.аудитад хамрагдсан байгууллагын санхүүгийн тайланд төрийн аудитын байгууллагаас санал, дүгнэлт өгөх боломжгүй бол;

39.2.2.төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй бол.

39.3.Энэ хуулийг зөрчсөн хүн, албан тушаалтан, хуулийн этгээдэд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

40 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

40.1. Энэ хуулийг 2018 оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.